



ИНД - 119

Иргэний Нисэхийн Дүрэм

Агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-119 нь төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага болон тухайн гэрчилгээжүүлэлтийн хадгалалтын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно. Төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд Агаарын тээврийн үйл ажиллагаа болон Арилжааны тээврийн үйл ажиллагаа багтана.

ИНД-119 нь гэрчилгээжүүлэлтийн хоёр түвшинг тогтооно:

- том, дунд болон жижиг агаарын хөлгөөр төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрдөг, шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- нисдэг тэрэг болон 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудалтай нисэх онгоцоор төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг, ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт.

ИНД-119 нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн ICAO-ийн стандарт болон байгууллагын гэрчилгээжүүлэлттэй холбоотой дүрмийн заалтын бүтцийг дагаж мөрддөг.

Тухайн бүтэц нь төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн (үйл ажиллагаа эхлүүлэх стандарт), үйл ажиллагааны (үйл ажиллагааны хадгалалт) болон аюулгүй байдлын аудитын (хяналт) тусгай шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-119-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-119, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 03 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 1	2002 оны 09 сарын 17
Нэмэлт, өөрчлөлт 2	2005 оны 09 сарын 14
Нэмэлт, өөрчлөлт 3	2007 оны 05 сарын 04
Нэмэлт, өөрчлөлт 4	2008 оны 09 сарын 11
Нэмэлт, өөрчлөлт 5	2010 оны 04 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 6 (Шинэчлэлт)	2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-119-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 119 A.16-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл.....	6
119.1. Зорилго.....	6
119.3. Тодорхойлолт	6
119.5. Гэрчилгээжих шаардлага	7
119.7. Нөөц	7
119.9. Гэрчилгээ эзэмших хүсэлт	7
119.11. Гэрчилгээ олгох	8
119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	8
119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт	9
119.17. Гэрчилгээний хугацаа.....	10
119.19. Үйл ажиллагаа зогсоох мэдэгдэл	10
119.21. Гэрчилгээ сунгах.....	10
В БҮЛЭГ - Шугамын агаарын тээвэрлэгч - гэрчилгээжүүлэлтийн шаардлага	10
119.51. Ажилтанд тавих шаардлага	10
119.53. Ажилтны ур чадварын шаардлага.....	12
119.55. Байгууламж, тоног төхөөрөмжийн шаардлага.....	12
119.57. Бататгах нислэг, эсхүл тест	13
119.59. Нөөц	13
119.61. Техник үйлчилгээний журам	13
119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр	14
119.65. Баримт бичиг	15
119.67. Ажилтны бүртгэл	16
119.69. Тоног төхөөрөмжийн бүртгэл.....	16
119.71. Нислэгийн зөвшөөрөл, хяналт	16
119.73. Нислэг дагах үйлчилгээ.....	17
119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.....	18
119.77. Үйл ажиллагааны журам тогтоох.....	18
119.79. Аюулгүй байдлын удирдлага	18
119.81. Шугамын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар	18
С БҮЛЭГ - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	20
119.101. Ажилтанд тавих шаардлага	20
119.103. Ажилтны ур чадварын шаардлага.....	21
119.105. Байгууламж, тоног төхөөрөмжийн шаардлага.....	22
119.107. Бататгах нислэг, эсхүл тест	22
119.109. Техник үйлчилгээний журам	22
119.111. Техник үйлчилгээний хөтөлбөр	23
119.113. Баримт бичиг	24
119.115. Ажилтны бүртгэл	24
119.117. Тоног төхөөрөмжийн бүртгэл.....	25
119.119. Нислэгийн зөвшөөрөл, хяналт	25
119.121. Нислэг дагах үйлчилгээ.....	26
119.123. Үйл ажиллагааны журам тогтоох.....	26

119.124.	Аюулгүй байдлын удирдлага	26
119.125.	Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар	27
D БҮЛЭГ - Үйл ажиллагааны шаардлага		28
119.151.	Байнгын хэрэгжилт	28
119.153.	Нислэгийн үйл ажиллагааны шаардлага	28
119.155.	Нисэх багийн гишүүдийн мэргэшил.....	29
119.157.	Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн чартер, давхар-түрээс болон түрээс	29
119.159.	Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлгийг ашиглах	30
119.161.	Бизнесийн, эсхүл худалдааны нэр	30
119.163.	Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт.....	30
119.165.	Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	31
119.167.	Техник үйлчилгээний хөтөлбөрийн өөрчлөлт	32
119.169.	[Хүчингүй].....	32
119.201.	ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаа эрхэлдэг шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт.....	32
119.203.	ИНД-135-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт.....	33
119.205.	Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт	35
119.207.	Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт	37
119.209.	Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагчийн, байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт	38
Хавсралт А - Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил, дадлага туршлага.....		40
A.1.	Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан.....	40
A.2.	Багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан	41
A.3.	Техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан	42
A.4.	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан.	44
A.5	Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан	44
Хавсралт В - Удирдах ажилтны мэргэшил, дадлага туршлага - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч		45
V.1.	Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан.....	45
V.2.	Багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан	46
V.3.	Техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан	46
V.4.	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан.	47
V.5.	Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан	47

А Бүлэг - Ерөнхий зүйл

119.1. Зорилго

(а) Энэ Дүрэм нь ИНД-121, ИНД-125 болон ИНД-135-ын дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол Улсад байнга оршин суугч этгээдийн гэрчилгээжүүлэлтийн болон түүний хадгалалтын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

119.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ гэж тухайн гэрчилгээ эзэмшигчид дараах эрх олгож буй агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг:

- (1) ИНД-121-ийн дагуу, шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410кг-аас дээш жинтэй нисэх онгоц ашиглан төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх; эсхүл
- (2) ИНД-125-ын дагуу, шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна 10-аас 30 хүртэлх зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410кг, эсхүл түүнээс бага, МСТOW нь 5700кг-аас дээш жинтэй нисэх онгоц ашиглан төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх; эсхүл
- (3) ИНД-125-ын дагуу SEIFR-ээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэх; эсхүл
- (4) ИНД-135-ын дагуу, шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, МСТOW нь 5700кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг ашиглан, SEIFR-ээр зорчигч тээвэрлэхээс бусад, төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх;

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ гэж шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг;

Ерөнхий заавар гэж агуулгыг өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, 119.81, эсхүл 119.125-д шаардсан Ерөнхий зааврыг;

Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ гэж тухайн эзэмшигчид, ИНД-135-ын дагуу шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, МСТOW нь 5700кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг ашиглан, SEIFR-ээр зорчигч тээвэрлэхээс бусад, төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгодог агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг.

119.5. Гэрчилгээжих шаардлага

(a) Төлбөрт нислэгийн үйл ажиллагааны, үйл ажиллагаа хариуцаж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших ёстой ба тухайн гэрчилгээний нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(b) Хууль болон энэ Дүрмийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээ болон түүний нөхцөлийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг чөлөөт нисэхийн үйл ажиллагаанаас бусад, төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

(c) Хэрэв тухайн этгээд нь дараах хоёр, эсхүл түүнээс олон үйл ажиллагаа хариуцдаг бол, энэ зүйлийн (a)-д заасан, төлбөрт нислэгийн үйл ажиллагааны, үйл ажиллагаа хариуцсан этгээд байна:

- (1) тухайн үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэж болох эсэхийг тодорхойлох;
- (2) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх багийн гишүүдийг томилох;
- (3) тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх багийн гишүүдийг үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл бусад хэлбэрээр авч ажиллуулах;
- (4) аюулгүй байдлын үндэслэлээр агаарын хөлгийн даргын гаргах шийдвэрээс бусад, үйл ажиллагааг өөрчлөх шийдвэр гаргах.

119.7. Нөөц**119.9. Гэрчилгээ эзэмших хүсэлт**

(a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24119/01 маягтыг бөглөх ба:

- (1) хүсэлт гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх нэр, хаяг;
- (2) 119.15(b)-д шаардсан, Үйл ажиллагааны тодорхойлолтод шаардлагатай дэлгэрэнгүй мэдээлэл;
- (3) дараах Ерөнхий заавар:
 - (i) шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хувьд, 119.81-д шаардсан; эсхүл
 - (ii) ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хувьд, 119.125-д шаардсан;
- (4) тухайн хүсэлт гаргагчтай холбоотой Даргын шаардаж болох, маягтад тусгагдсан нэмэлт тодруулга-

тухайн богино хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, төлөвлөсөн үйл ажиллагааг эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлсэн байна.

119.11. Гэрчилгээ олгох

(a) Хэрэв Дарга дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, тухайн хүсэлт гаргагч нь хуулийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) тухайн хүсэлт гаргагч нь В Бүлгийн холбогдох шаардлага;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь хувь хүн бол, 119.51(а)(1), (2)-т шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх шаардлага;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх;

(b) Хэрэв Дарга дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, тухайн хүсэлт гаргагч нь хуулийн дагуу ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) тухайн хүсэлт гаргагч нь С Бүлгийн холбогдох шаардлага;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь хувь хүн бол, 119.101(а)(1), (2)-т шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх шаардлага;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчийн гүйцэтгэх зөвшөөрөгдсөн эрхийг заана.

(b) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь тухайн гэрчилгээ эзэмшигчид дараах үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно:

- (1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд заасан төлбөрт нислэгийн үйл ажиллагаа;
- (2) ашиглаж байгаа, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа тухайн агаарын хөлөгтэй хамаарах газрын бэлтгэл, эсхүл нислэгийн сургалт;
- (3) нисэх багийн гишүүдийн ур чадварыг тодорхойлох тест, эсхүл шалгалтын нислэг;
- (4) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан үйлчилгээ үзүүлдэг, эсхүл үйл ажиллагаа гүйцэтгэдэг бусад этгээдийн ур чадварыг тодорхойлох тест, эсхүл шалгалт.

119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Хууль болон энэ Дүрмийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд энэ зүйлийн (b)-д заасан Үйл ажиллагааны тодорхойлолтыг хавсаргасан байх ёстой.

(b) Үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны үндсэн баазын байрлалын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улс дахь үйлчилгээний хаяг;
- (3) тухайн гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаа эрхэлж болох бизнесийн бусад нэр;
- (4) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлөг бүрийн маяг, серийн болон бүртгэлийн дугаар;
- (5) тухайн зөвшөөрөгдсөн төлбөрт нислэгийн үйл ажиллагааны төрлийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (6) нислэгийн үйл ажиллагааны чиглэлийн болон бүсийн зөвшөөрөл, хязгаарлалт;
- (7) энэ дүрэм, эсхүл бусад Дүрмийн шаардлагаас чөлөөлсөн мэдээлэл;
- (8) тодорхой нөхцөл байдлыг зохицуулах зорилгоор Даргын шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

(c) Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод SEIFR-ээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны зөвшөөрөл олгохдоо, Дарга тухайн зөвшөөрлийн хугацааг Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацаанаас богино хугацаагаар тогтоож болно.

(d) Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод EDTO-ийн зөвшөөрөл олгохдоо, Дарга дараах мэдээллийг заах үүрэгтэй:

- (1) EDTO-д зөвшөөрөгдсөн нисэх онгоц бүрийн бүртгэлийн дугаар;
- (2) энэ хэсгийн (1)-ийн дагуу EDTO-д зөвшөөрөгдсөн нисэх онгоц бүрийн максимум даялалтын хугацаа;
- (3) EDTO-д зөвшөөрөгдсөн EDTO нөөц аэродром.

119.17. Гэрчилгээний хугацаа

- (a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) Гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл Дарга гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, тухайн гэрчилгээ нь хүчинтэй хэвээр байна.
- (c) Хугацаа нь дууссан, эсхүл хүчингүй болсон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.
- (d) Түдгэлзүүлсэн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь зохих тэмдэглэл хийлгэхээр тухайн гэрчилгээг Даргад хүргүүлнэ.

119.19. Үйл ажиллагаа зогсоох мэдэгдэл

Төлбөрт нислэгийн үйл ажиллагаагаа зогсоосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь зогсоосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.

119.21. Гэрчилгээ сунгах

- (a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24119/01 маягтын дагуу гаргана.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан хүсэлтийг, тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацаа заагаагүй бол, тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

В БҮЛЭГ - Шугамын агаарын тээвэрлэгч - гэрчилгээжүүлэлтийн шаардлага**119.51. Ажилтанд тавих шаардлага**

- (a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл бусад хэлбэрээр авч ажиллуулах үүрэгтэй:
 - (1) гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан:
 - (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлж, энэ Дүрэмд заасан шаардлага, стандартын дагуу хийж чадахаа тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;
 - (ii) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах хариуцлага хүлээх;

(2) удирдах ажилтнууд:

- (i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах хариуцлага хүлээх;
- (ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан үйл ажиллагаанд хариуцлага хүлээх;
- (iii) гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;

(3) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан удирдах ажилтнууд нь дараах үүрэгтэй:

(1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хэмжээ, төлөвлөж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан өөр хэлбэрээр Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, дараах нэгээс дээшгүй үйл ажиллагаа тус бүрийг хариуцах:

- (i) нислэгийн үйл ажиллагаа болон газрын үйлчилгээний үйл ажиллагааг багтаасан төлбөрт нислэгийн үйл ажиллагаа;
- (ii) багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ;
- (iii) техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт;
- (iv) 119.79-ийн дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (v) агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалт, хэрэв 119.75-д агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр шаардсан бол;
- (vi) ИНД-12-ын дагуу хэрэг явдлыг шинжлэн шалгах;

(2) тэдний хариуцлага хүлээх үйл ажиллагаанд хамаарах, Хавсралт А-д заасан минимум мэргэшил, ур чадвар болон дадлага туршлагыг эзэмшсэн байх.

(c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-ыг үл харгалзан, хэрэв тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын бүтцэд тохирох бол, ур чадварын үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлагыг, энэ зүйлийн (b)(1)(i)-ийн дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтанд нэгтгэж болно.

(d) Тухайн ажлыг хариуцсан удирдах ажилтан нь хариуцлагаа өөртөө хадгалсан хэвээр байх ба тухайн эрх шилжүүлэх нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц бол, энэ зүйлийн (b)(1)-д заасан ажил үүргийг өөр ажилтанд шилжүүлж болно.

119.53. Ажилтны ур чадварын шаардлага

(а) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын Ерөнхий зааварт заасан төлбөрт нислэгийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтнуудын анхан шатны үнэлгээ хийх, тэдгээрийн ур чадварыг хадгалах;
- (2) ажилтнуудад, тэдний эрхийн хүрээг нотлох, бичгээр үйлдсэн баримт олгодог болохыг бататгах.

(b) Хүсэлт гаргагч нь, ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн байх ба тухайн гэрчилгээгээр энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хүсэлт гаргагчийн ажилтнуудын ур чадварыг хадгалах зорилгоор үнэлгээ хийх, эсхүл сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх зохих ёсоор олгогдсон байгууллагатай гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу бусад байгууллагатай гэрээ байгуулсан хүсэлт гаргагч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг Ерөнхий заавартаа оруулсан байна:

- (1) тухайн байгууллагад шилжүүлэх ажил;
- (2) тухайн байгууллагын зохион байгуулах сургалт, эсхүл авах шалгалтын цар хүрээ;
- (3) сургалт зохион байгуулах, эсхүл шалгалт авахтай холбоотой тухайн байгууллагын эрх.

119.55. Байгууламж, тоног төхөөрөмжийн шаардлага

(а) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц дараах шаардлагыг хангасан байгууламж, тоног төхөөрөмжтэй байна:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангасан байх;
- (2) шаардлагатай тохиолдолд:
 - (i) байр сууц, албан тасалгаа, засвар үйлчилгээний ажлын байр, ангар болон барилга байгууламж;
 - (ii) Ерөнхий зааварт заасан үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, сургалтын туслах хэрэгсэл, өгөгдөхүүн болон баримт бичгийг багтаасан байх.

(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлага хангасан ажлын орчин нөхцөлийг бүрдүүлснийг бататгана:

- (1) тухайн гүйцэтгэх ажилд тохиромжтой байх;
- (2) шаардлагатай тохиолдолд, цаг агаарын нөхцөлөөс хамгаалагдсан байх.

119.57. Бататгах нислэг, эсхүл тест

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших, эсхүл гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь, хэрэв Дарга шаардсан бол, холбогдох тогтоосон аливаа шаардлагыг хангаж чадахыг Даргад нотлох зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийнэ.

(b) Тухайн нислэг, эсхүл тестийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр гүйцэтгэнэ.

119.59. Нөөц

119.61. Техник үйлчилгээний журам

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, дараах агаарын хөлөг, тоног төхөөрөмжийн НТЧ-ын хадгалалтыг бататгах журам тогтоох үүрэгтэй:

(1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг;

(2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн аливаа төхөөрөмж.

(b) Тухайн хүсэлт гаргагчийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, 119.81-ийн дагуу шаардсан Ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаах үүрэгтэй:

(1) бусад этгээдэд шилжүүлэх ажил;

(2) бусад этгээдийн гүйцэтгэх тухайн техник үйлчилгээний цар хүрээ;

(3) тухайн гүйцэтгэх ажил, техник үйлчилгээтэй холбоотой бусад этгээдийн эрх.

119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр

(а) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг бүрд зориулсан техник үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулсан байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (а)-гийн дагуу шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн хөтөлбөрт хамрагдах агаарын хөлөг бүрийн маяг, бүртгэлийн болон серийн дугаар;
- (2) дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийн хамт, агаарын хөлгийн их бие, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл болон ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг, шалгалтыг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх журам, зааварчилгаа:
 - (i) заавал үзлэг хийсэн байх;
 - (ii) хэрэв техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл зориулалтын бус материал, эсхүл эд анги ашигласан бол, тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд татгалзал, доголдол, эсхүл гэмтэл учруулж болох;
- (3) ашиглалтын хугацаа, цикл, календарын хугацаа болон үйл ажиллагаанд байгаа системийн тоо, эсхүл тэдгээрийн аливаа хослолоор илэрхийлэгдэх, энэ зүйлийн (b)(2)-ын дагуу техник үйлчилгээг гүйцэтгэх хуваарь;
- (4) агаарын хөлгийг тухайн техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэн оруулах журам;
- (5) хэрэв хөтөлбөр нь нөхцөлөөр хянах техник үйлчилгээ (condition monitored maintenance), эсхүл бодит байдал болон ашиглалтын мониторингийн (health and usage monitoring) системээс гарсан мэдээллийг ашигладаг бол, техник үйлчилгээний явц / өрнөлтөд дүгнэлт хийх журам;
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрөөр шаардсан үзлэг бүрийг хийсэн болохыг бататгах журам;
- (7) хэрхэн бүртгэл хөтлөх жишээг багтаасан, гэмтлийг бүртгэх журам;
- (8) гэмтлийг засах, эсхүл түүнийг хойшлуулах журам;
- (9) ашиглалтын туршлагад үндэслэн үзлэгийн үечлэлийг өөрчлөх журам;
- (10) ИНД-91.623-ийн дагуу техник үйлчилгээний бүртгэлийг хадгалах журам.

119.65. Баримт бичиг

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь түүний үйл ажиллагаа, аюулгүй байдал болон техник үйлчилгээний өгөгдөхүүнийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журмыг тогтоосон байна.

(b) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-91, ИНД-108, ИНД-121, ИНД-125 болон ИНД-135-ыг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, аливаа холбогдох бусад Дүрмээр шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоосон байна.

(c) Энэ зүйлийн (a), (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох эрх бүхий этгээд хянаж, зөвшөөрдөг байх;
- (2) бүх холбогдох баримт бичгийн хүчинтэй хувилбарыг, тэдгээрийг ажилтан авч хэрэглэхэд шаардлагатай бүх байрлалд хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр бэлэн байлгах;
- (3) хүчингүй болсон бүх баримт бичгийг боловсруулсан, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс яаралтай хураадаг байх;
- (4) баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж баталдаг байх;
- (5) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хүчинтэй хувийг таньж тодорхойлж чаддаг байх.

119.67. Ажилтны бүртгэл

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журам тогтоох үүрэгтэй:

- (1) дараах бүртгэлийг үнэн зөв хөтлөх:
 - (i) тухайн ажил үүргээ гүйцэтгэхэд нь үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшсэн байхыг шаарддаг ажилтан бүрийн;
 - (ii) Даргын шилжүүлсэн аливаа эрх, эсхүл ажил үүргийг хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн;
 - (iii) тухайн гэрчилгээ эзэмшигчийн олгосон аливаа эрхийг хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн;
- (2) тухайн бүртгэлд дараах дэлгэрэнгүй мэдээлэл багтсан байна:
 - (i) энэ хэсгийн (1)-д заасан ажилтан бүрийн холбогдох дадлага туршлага, мэргэшил болон сургалт;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан аливаа үнэмлэх, эсхүл зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй байдал болон хугацаа;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-т заасан шилжүүлсэн эрх, үүрэг;
 - (iv) энэ хэсгийн (1)(iii)-т заасан эрх;
- (3) бүртгэлийг дараах өдрөөс хойш 3 жилийн хугацаагаар хадгалах:
 - (i) тухайн ажилтан үнэмлэх, эсхүл зэрэглэл шаардсан ажил үүргээ гүйцэтгэхээ зогсоосон, эсхүл
 - (ii) аливаа шилжүүлсэн эрх үүрэг, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн олгосон эрхийг хэрэгжүүлж байгаа.

119.69. Тоног төхөөрөмжийн бүртгэл

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг аливаа аюулгүй байдлын-эрсдэлтэй тоног төхөөрөмжийн тест, үзлэг болон тохируулгыг үнэн зөв бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтооно;
- (2) энэ хэсгийн (1)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг, бүртгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгална.

119.71. Нислэгийн зөвшөөрөл, хяналт

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, нислэгийг, эсхүл бүлэг нислэгийг санаачлах, үргэлжлүүлэх болон цуцлахыг 119.51(b)(1)(i)-д шаардсан этгээд зөвшөөрдөг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

119.73. Нислэг дагах үйлчилгээ

(a) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө хүргүүлэлгүй гүйцэтгэж байгаа аливаа төлбөрт нислэгийн үйл ажиллагааг, нислэг дагах үйлчилгээгээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй.

(b) Нислэг дагах үйлчилгээгээр хангагдаж байгаа төлбөрт нислэгийн үйл ажиллагаа бүрийн хувьд, тухайн нислэг дагах үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь дараах шаардлага хангасан болохыг энэ зүйлийн (a)-д шаардсан журам бататгах ёстой:

- (1) ИНД-91.307(c)-гийн дагуу шаардсан ИХНД-ийн нислэгийн төлөвлөгөөний мэдээлэлтэй байх;
- (2) тухайн төлбөрт нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэж дуусгах урьдчилан тохирсон цагийн мэдээлэлтэй байх;
- (3) энэ зүйлийн (c)-г харгалзан, хэрэв тухайн нислэгийг холбоо байнга хадгалах боломжгүй бүсэд гүйцэтгэх бол, холбоог эргэн тогтоох цагийн мэдээлэлтэй байх;
- (4) тухайн нислэг дагах үйлчилгээний талаар хөлгийн даргад мэдээлэх, үйл ажиллагааны аюулгүй байдалтай холбоотой байж болох бусад зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх;
- (5) дараах байгууллагад тодорхой цагт мэдээлэл өгдөг байх:
 - (i) үндэсний эрэн хайх, авран туслах ажиллагааг зохицуулах төвд; эсхүл
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, онцгой нөхцөлийн арга хэмжээ авах чадвартай байгууллагад -

хэрэв тухайн хөлгийн дарга энэ хэсгийн (2), (3), эсхүл (4)-ийн дагуу, тухайн урьдчилан тохирсон цагт холбоо тогтоож чадаагүй бол.

(c) Тухайн илүү урт хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, агаарын хөлөг нь энэ зүйлийн (b)(3)-ын дагуу 30 минутаас дээш хугацаагаар холбоогүй байж болохгүй.

119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

(а) Шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна, 9-өөс дээш зорчигчийн суудлын конфигурацитай агаарын хөлгөөр Монгол Улсаас, эсхүл Монгол Улсад тогтмол агаарын тээврийн зорчигч үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-108-ын шаардлага хангасан агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх үүрэгтэй.

119.77. Үйл ажиллагааны журам тогтоох

Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэтгэхээр төлөвлөж байгаа төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд мөрдөх, энэ Дүрмийн болон аливаа бусад дүрмийн шаардлагыг хангасан журам тогтоосон байна.

119.79. Аюулгүй байдлын удирдлага

Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх болон хадгалах үүрэгтэй.

119.81. Шугамын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар

(а) Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан байгууллагын Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар, түүнд агуулагдсан аливаа журмыг баталгаажуулж, хүсэлт гаргагчийн байгууллагын өмнөөс гүйцэтгэх захирлын гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) энэ Дүрэм, холбогдох бусад Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр, аргыг харуулж, тухайн агаарын тээвэрлэгчийн байгууллагыг тодорхойлсон;
 - (ii) тухайн байгууллагын ажилтнууд байнга дагаж мөрдөхийг шаардсан;
- (1A) 119.79-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотойгоор:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 119.51(a)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнуудын нэр, албан тушаал;
- (3) 119.51(a)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
 - (i) тэдний хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой асуудлаар тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;

-
- (4) агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор хүсэлт гаргагчийн ажилтнууд байрлаж байгаа байрлал бүрийн үйл ажиллагааны цар хүрээний хураангуй мэдээлэл;
 - (5) 119.51(а)(1), (а)(2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг энэ зүйлийн (а)(4)-д заасан ажлын байр тус бүрээр харуулсан байгууллагын бүтцийн зураг;
 - (6) энэ зүйлийн (а)(4)-д заасан байрлал тус бүрийн ажилтнуудын бүтцийн хураангуй мэдээлэл;
 - (6А) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
 - (7) үйл ажиллагааны үндсэн байрлал, хэрэв хамааралтай бол, үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (8) 119.55-д шаардсан байгууламж, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (9) энэ Дүрэмд шаардсан журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (10) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) 119.61-д шаардсан техник үйлчилгээний журмын;
 - (ii) 119.63-т шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн;
 - (iii) хүсэлт гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгэх техник үйлчилгээний байгууллагын;
 - (11) энэ Дүрэм болон ИНД-121, ИНД-125, эсхүл ИНД-135-д шаардсан холбогдох хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (12) хүсэлт гаргагчийн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тухайн гадаад улсын хууль дүрмийг дагаж мөрдөхийг бататгах журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (13) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С БҮЛЭГ - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

119.101. Ажилтанд тавих шаардлага

(а) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл бусад хэлбэрээр авч ажиллуулах үүрэгтэй:

(1) гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан:

- (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлж, энэ Дүрэмд заасан шаардлага, стандартын дагуу хийж чадахаа тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;
- (ii) тухайн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах хариуцлага хүлээх;

(2) удирдах ажилтнууд:

- (i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах хариуцлага хүлээх;
- (ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан үйл ажиллагаанд хариуцлага хүлээх;
- (iii) гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;

(3) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан удирдах ажилтнууд нь дараах үүрэгтэй:

(1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хэмжээ, төлөвлөж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан өөр хэлбэрээр Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, дараах нэгээс дээшгүй үйл ажиллагаа тус бүрийг хариуцах:

- (i) нислэгийн үйл ажиллагаа болон газрын үйлчилгээний үйл ажиллагааг багтаасан төлбөрт нислэгийн үйл ажиллагаа;
- (ii) багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ;
- (iii) техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт;
- (iv) 119.124-ийн дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (v) ИНД-12-ын дагуу хэрэг явдлыг шинжлэн шалгах;

(2) тэдний хариуцлага хүлээх үйл ажиллагаанд хамаарах, Хавсралт В-д заасан минимум мэргэшил, ур чадварыг эзэмшсэн байх.

(c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-ыг үл харгалзан, хэрэв тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын бүтцэд тохирох бол, ур чадварын үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлагыг, энэ зүйлийн (b)(1)(i)-ийн дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтанд нэгтгэж болно.

119.103. Ажилтны ур чадварын шаардлага

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын Ерөнхий зааварт заасан төлбөрт нислэгийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтнуудын анхан шатны үнэлгээ хийх, тэдгээрийн ур чадварыг хадгалах;
- (2) ажилтнуудад, тэдний эрхийн хүрээг нотлох, бичгээр үйлдсэн баримт олгодог болохыг бататгах.

(b) Хүсэлт гаргагч нь, ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн байх ба тухайн гэрчилгээгээр энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу хүсэлт гаргагчийн ажилтнуудын ур чадварыг хадгалах зорилгоор үнэлгээ хийх, эсхүл сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх зохих ёсоор олгогдсон байгууллагатай гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу бусад байгууллагатай гэрээ байгуулсан хүсэлт гаргагч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг Ерөнхий заавартаа оруулсан байна:

- (1) тухайн байгууллагад шилжүүлэх ажил;
- (2) тухайн байгууллагын зохион байгуулах сургалт, эсхүл авах шалгалтын цар хүрээ;
- (3) сургалт зохион байгуулах, шалгалт авахтай холбоотой тухайн байгууллагын эрх.

(d) Хүсэлт гаргагч нь, энэ зүйлийн (b)-гийн оронд нөөцөөр, зохих ёсоор мэргэшсэн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн гүйцэтгэх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц гадны шалгалт, эсхүл сургалтын хөтөлбөрийг ашиглаж болно.

119.105. Байгууламж, тоног төхөөрөмжийн шаардлага

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц дараах шаардлагыг хангасан байгууламж, тоног төхөөрөмжтэй байна:

- (1) тухайн хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангасан байх;
- (2) шаардлагатай тохиолдолд:
 - (i) байр сууц, албан тасалгаа, засвар үйлчилгээний ажлын байр, ангар болон барилга байгууламж;
 - (ii) Ерөнхий зааварт заасан үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, сургалтын туслах хэрэгсэл, өгөгдөхүүн болон баримт бичгийг багтаасан байх.

(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлага хангасан ажлын орчин нөхцөлийг бүрдүүлснийг бататгана:

- (1) тухайн гүйцэтгэх ажилд тохиромжтой байх;
- (2) шаардлагатай тохиолдолд, цаг агаарын нөхцөлөөс хамгаалсан байх.

119.107. Бататгах нислэг, эсхүл тест

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших, эсхүл гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь хэрэв Дарга шаардсан бол, холбогдох тогтоосон тухайн шаардлагыг хангаж чадахыг Даргад нотлох зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийнэ.

(b) Тухайн нислэг, эсхүл тестийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр гүйцэтгэнэ.

119.109. Техник үйлчилгээний журам

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах агаарын хөлөг, тоног төхөөрөмжийн НТЧ-ын хадгалалтыг бататгах журам тогтоох үүрэгтэй:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг;
- (2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн аливаа төхөөрөмж.

(b) Тухайн хүсэлт гаргагчийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, 119.125-ын дагуу шаардсан Ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаах үүрэгтэй:

- (1) бусад этгээдэд шилжүүлэх ажил;
- (2) бусад этгээдийн гүйцэтгэх тухайн техник үйлчилгээний цар хүрээ;
- (3) тухайн гүйцэтгэх ажил, техник үйлчилгээтэй холбоотой бусад этгээдийн эрх.

119.111. Техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг бүрд зориулсан техник үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулсан байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-гийн дагуу шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн хөтөлбөрт хамрагдах агаарын хөлөг бүрийн бүртгэл, маягийн болон серийн дугаар;
- (2) дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийн хамт, агаарын хөлгийн их бие, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл болон ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг, шалгалтыг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх журам, зааварчилгаа:
 - (i) заавал үзлэг хийсэн байх;
 - (ii) хэрэв техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй, эсхүл зориулалтын бус материал, эсхүл эд анги ашигласан бол, тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд татгалзал, доголдол, эсхүл гэмтэл учруулж болох;
- (3) ашиглалтын хугацаа, цикл, календарын хугацаа болон үйл ажиллагаанд байгаа системийн тоо, эсхүл тэдгээрийн аливаа хослолоор илэрхийлэгдэх, энэ зүйлийн (b)(2)-ын дагуу техник үйлчилгээг гүйцэтгэх хуваарь;
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэн оруулах журам;
- (5) хэрэв хөтөлбөр нь нөхцөлөөр хянах техник үйлчилгээ (condition monitored maintenance), эсхүл бодит байдал болон ашиглалтын мониторингийн (health and usage monitoring) системээс гарсан мэдээллийг ашигладаг бол, техник үйлчилгээний явц / өрнөлтөд дүгнэлт хийх журам;
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрөөр шаардсан үзлэг бүрийг хийсэн болохыг бататгах журам;
- (7) хэрхэн бүртгэл хөтлөх жишээг багтаасан, гэмтлийг бүртгэх журам;
- (8) гэмтлийг засах, эсхүл түүнийг хойшлуулах журам;
- (9) ашиглалтын туршлагад үндэслэн үзлэгийн үечлэлийг өөрчлөх журам;
- (10) ИНД-91.623-ийн дагуу техник үйлчилгээний бүртгэлийг хадгалах журам.

119.113. Баримт бичиг

(a) 119.124(с)-д заасны дагуу удирдлагын тогтолцоо шаардлагатай Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь түүний үйл ажиллагаа, аюулгүй байдал болон техник үйлчилгээний өгөгдөхүүнийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журмыг тогтоосон байна.

(b) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-91, ИНД-135-ыг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, аливаа холбогдох бусад Дүрмээр шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоосон байна.

(c) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох эрх бүхий этгээд хянаж, зөвшөөрдөг байх;
- (2) бүх холбогдох баримт бичгийн хүчинтэй хувилбарыг, тэдгээрийг ажилтан авч хэрэглэхэд шаардлагатай бүх байрлалд хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр бэлэн байлгах;
- (3) хүчингүй болсон бүх баримт бичгийг боловсруулсан, эсхүл хэрэглэж байгаа бүх цэгээс яаралтай хураадаг байх;
- (4) баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж баталдаг байх;
- (5) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хүчинтэй хувийг таньж тодорхойлдог байх.

119.115. Ажилтны бүртгэл

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) дараах бүртгэлийг үнэн зөв хөтлөх:
 - (i) ажил үүргээ гүйцэтгэхэд нь үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшсэн байхыг шаарддаг ажилтан бүрийн;
 - (ii) Даргын шилжүүлсэн аливаа эрх, эсхүл ажил үүргийг хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн;
 - (iii) тухайн гэрчилгээ эзэмшигчээс олгосон аливаа эрхийг хэрэгжүүлж байгаа ажилтан бүрийн;
- (2) тухайн бүртгэлд дараах дэлгэрэнгүй мэдээлэл багтсан байна:
 - (i) энэ хэсгийн (1)-д заасан ажилтан бүрийн холбогдох дадлага туршлага, мэргэшил болон сургалтын талаар;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан аливаа үнэмлэх, эсхүл зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй байдал болон хугацааны талаар;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-т заасан шилжүүлсэн эрх, үүргийн талаар;
 - (iv) энэ хэсгийн (1)(iii)-т заасан эрхийн талаар;
- (3) бүртгэлийг дараах өдрөөс хойш 1 жилийн хугацаагаар хадгалах:

- (i) тухайн ажилтан үнэмлэх, эсхүл зэрэглэл шаардсан ажил үүргээ гүйцэтгэхээ зогсоосон, эсхүл
- (ii) аливаа шилжүүлсэн эрх үүрэг, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн олгосон эрхийг хэрэгжүүлж байгаа.

119.117. Тоног төхөөрөмжийн бүртгэл

Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг аливаа аюулгүй байдлын-эрсдэлтэй тоног төхөөрөмжийн тест, үзлэг болон тохируулгыг үнэн зөв бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтооно;
- (2) энэ хэсгийн (1)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг, бүртгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгална.

119.119. Нислэгийн зөвшөөрөл, хяналт

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэг, эсхүл бүлэг нислэгийг санаачлах, үргэлжлүүлэх болон цуцлахыг 119.101(b)(1)(i)-д шаардсан этгээд зөвшөөрдөг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

119.121. Нислэг дагах үйлчилгээ

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө хүргүүлэлгүй гүйцэтгэж байгаа аливаа төлбөрт нислэгийн үйл ажиллагааг, нислэг дагах үйлчилгээгээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоох үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь, төлбөрт нислэгийн үйл ажиллагаа бүрийг нислэг дагах үйлчилгээгээр хангах ба тухайн нислэг дагах үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь дараах шаардлага хангасан болохыг бататгах ёстой:

- (1) ИНД-91.307(с)-гийн дагуу шаардсан ИХНД-ийн нислэгийн төлөвлөгөөний мэдээлэлтэй байх;
- (2) тухайн төлбөрт нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэж дуусгах урьдчилан тохирсон цагийн мэдээлэлтэй байх;
- (3) энэ зүйлийн (с)-г харгалзан, хэрэв тухайн нислэгийг холбоо байнга хадгалах боломжгүй бүсэд гүйцэтгэх бол, холбоог эргэн тогтоох цагийн мэдээлэлтэй байх;
- (4) тухайн нислэг дагах үйлчилгээний талаар хөлгийн даргад мэдээлэх, үйл ажиллагааны аюулгүй байдалтай холбоотой байж болох бусад зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх;
- (5) дараах байгууллагад тодорхой цагт мэдээлэл өгдөг байх:
 - (i) үндэсний эрэн хайх, авран туслах ажиллагааг зохицуулах төвд; эсхүл
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, онцгой нөхцөлийн арга хэмжээ авах чадвартай байгууллагад.

хэрэв тухайн хөлгийн дарга энэ хэсгийн (2), (3), эсхүл (4)-ийн дагуу, тухайн урьдчилан тохирсон цагт холбоо тогтоож чадаагүй бол.

(c) Агаарын хөлөг нь энэ зүйлийн (b)(3)-ын дагуу дараах хугацаагаар холбоогүй байж болно:

- (1) хэрэв агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол, 30 минутаас дээшгүй хугацаанд; эсхүл
- (2) хэрэв арилжааны тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол, (a)-д заасан журмын дагуу тухайн нислэгийг үйлдэхийн өмнө тогтоосон тухайн хугацаанд.

119.123. Үйл ажиллагааны журам тогтоох

Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн болон аливаа бусад дүрмийн шаардлагыг хангасан журмыг тогтоосон байна.

119.124. Аюулгүй байдлын удирдлага

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх болон хадгалах үүрэгтэй.

119.125. Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар

(a) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан байгууллагын Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар, түүнд агуулагдсан аливаа журмыг баталгаажуулж, хүсэлт гаргагчийн байгууллагын өмнөөс гүйцэтгэх захирлын гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) энэ Дүрэм, холбогдох бусад Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр, аргыг харуулж, тухайн агаарын тээвэрлэгчийн байгууллагыг тодорхойлсон;
 - (ii) тухайн байгууллагын ажилтнууд байнга дагаж мөрдөх;
- (1A) 119.124-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотойгоор:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлсон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 119.101(a)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнуудын нэр, албан тушаал;
- (3) 119.101(a)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
 - (i) тэдний хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой асуудлаар тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) хэрэв хамааралтай бол, 119.101(a)(1), (a)(2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (4A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (5) үйл ажиллагааны үндсэн байрлал, техник үйлчилгээний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (6) энэ Дүрэмд шаардсан хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) 119.109-д шаардсан техник үйлчилгээний журмын;
 - (ii) 119.111-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн;
 - (iii) хүсэлт гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгэх техник үйлчилгээний байгууллагын;

- (8) энэ Дүрэм болон ИНД-135-д шаардсан холбогдох хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (9) хүсэлт гаргагчийн агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тухайн гадаад улсын хууль дүрмийг дагаж мөрдөхийг бататгах хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (10) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

D БҮЛЭГ - Үйл ажиллагааны шаардлага

119.151. Байнгын хэрэгжилт

- (a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (b) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:
 - (1) В Бүлэг, эсхүл С Бүлгийн холбогдох шаардлагыг дагаж мөрдөх, стандартыг тогтмол хангах;
 - (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй тусгасан хөтөлбөр, журмыг дагаж мөрдөх;
 - (3) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан байрлал бүрд:
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтын 1-ээс доошгүй хүчинтэй хувийг хадгалах;
 - (ii) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын, тухайн байрлал дахь үйл ажиллагаанд хамаарах хэсгийн 1-ээс доошгүй хүчинтэй хувийг хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хадгалах.

119.153. Нислэгийн үйл ажиллагааны шаардлага

- (a) Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь:
 - (1) шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410кг-аас дээш жинтэй нисэх онгоцны хувьд, ИНД-121-ийн холбогдох үйл ажиллагааны шаардлагыг; эсхүл
 - (2) шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна, 10-аас 30 хүртэл зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410кг, эсхүл түүнээс доош ба МСТOW нь 5700кг-аас дээш жинтэй нисэх онгоцны хувьд, ИНД-125-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг; эсхүл
 - (3) шаардлагатай багийн гишүүдийн суудлаас гадна, 9, эсхүл түүнээс цөөн тооны зорчигчийн суудлын конфигурацитай, МСТOW нь 5700кг, эсхүл түүнээс доош

жинтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний хувьд, энэ зүйлийн (b)-г харгалзан, ИНД-135-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг.

(b) SEIFR-ээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-125-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөнө.

(c) Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-135-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөнө.

119.155. Нисэх багийн гишүүдийн мэргэшил

(a) Тухайн этгээд нь ИНД-61-ийн дагуу, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай эрхийг багтаасан, хүчинтэй үнэмлэх, зэрэглэл эзэмшдэг байхаас бусад тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь аливаа этгээдийг төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй ба аливаа этгээд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй.

(b) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн этгээд нь, энэ зүйлийн (a)-д шаардсан мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн хүчинтэй гэрчилгээг биедээ авч явна.

119.157. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн чартер, давхар-түрээс болон түрээс

(a) Агаарын хөлгийг бусад агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчээс нисэх багтай, эсхүл нисэх баггүйгээр чартер хийх, давхар-түрээслэх, эсхүл түрээсэлж байгаа агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийг төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд ашиглахын өмнө үйл ажиллагааг аль агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэхийг тухайн тээвэрлэгчтэй хамтран тодорхой тогтоож, хөлгийн даргад мэдэгдэнэ.

(b) Агаарын хөлгийг агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшдэггүй этгээдээс нисэх багтай, эсхүл нисэх баггүйгээр чартер хийх, давхар-түрээслэх, эсхүл түрээсэлж байгаа агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн үйл ажиллагааг өөрийн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

(c) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч бүр нь, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр бичгээр үйлдсэн чартер, давхар-түрээс, эсхүл түрээсийн зохицуулалтын хувийг, тухайн зохицуулалтын дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1-ээс доошгүй жилийн хугацаагаар хадгална.

(d) Чартер, давхар-түрээс, эсхүл түрээсийн зохицуулалтыг амаар хийсэн тохиолдолд, тухайн гэрчилгээ эзэмшигч нь тухайн зохицуулалтын нөхцөлүүдийг тогтоосон санамж бичиг, түүнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг, тухайн зохицуулалтын дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1-ээс доошгүй жилийн хугацаагаар хадгална.

119.159. Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлгийг ашиглах

(а) Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлгийг чартер хийх, түрээслэх, эсхүл бусад ижил төстэй зохицуулалтаар ашиглах агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, тухайн богино хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө тухайн чартер, түрээс, эсхүл бусад ижил төстэй зохицуулалтын үндсэн нөхцөлийн талаар, дараах мэдээллийн хамт Даргад мэдэгдэнэ:

- (1) тухайн агаарын хөлгийг нийлүүлэгч нь ICAO-ийн хэлэлцэн тохирогч Улсаас төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөлтэй эсэх;
- (2) тухайн зохицуулалтад оролцогч талуудын нэр;
- (3) тухайн зохицуулалтын үргэлжлэх хугацаа;
- (4) тухайн зохицуулалтад оролцож байгаа агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэлийн дугаар болон маяг,

(б) Гэрчилгээ эзэмшигч нь төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг ашиглахаас өмнө Даргаас зөвшөөрөл авсан байна.

119.161. Бизнесийн, эсхүл худалдааны нэр

(а) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь төлбөрт нислэгийн үйл ажиллагааг тухайн гэрчилгээнд заасан худалдааны, эсхүл бизнесийн нэрээр гүйцэтгэнэ.

(б) Аливаа этгээд, тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа худалдааны, эсхүл бизнесийн нэрийг зорчигчид агаарын хөлөгт суухаас өмнө ил харагдахуйц, танигдахуйц, гаргацтай хэлбэрээр байрлуулсан байхаас бусад тохиолдолд, төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь, өөрийн гүйцэтгэж байгаа аливаа төлбөрт нислэгийн үйл ажиллагааны зар сурталчилгаа хийхдээ, гэрчилгээнд заасан тухайн хууль ёсны бизнесийн, эсхүл худалдааны нэрийг тодорхой харуулна.

119.163. Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт

Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээтэй байхаас бусад тохиолдолд, ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, ИНД-121, эсхүл ИНД-125-д хамаарах үйл ажиллагаа эрхлэхгүй.

119.165. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) Ерөнхий зааврын өөрчлөлт нь, байгууллагын үндсэн чиг үүрэг, тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийсэн болохыг бататгах;
- (2) Ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрэм, эсхүл холбогдох бусад дүрмийн шаардлагад нийцэж байгаа ба Ерөнхий зааварт агуулагдсан нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийсэн болохыг бататгах;
- (3) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд тухайн нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад хадгалуулахаар цаг алдалгүй хүргүүлэх;
- (4) нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий заавартаа оруулах.

(b) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах аливаа өөрчлөлтийг хийхээс өмнө, Даргаас урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай:

- (1) гүйцэтгэх захирал;
- (2) нэр заагдсан удирдах ажилтнууд;
- (3) тухайн гэрчилгээ эзэмшигч төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг 119.81(a)(7), эсхүл 119.125(a)(5)-ын дагуу Ерөнхий зааварт заасан аль хамааралтай байрлал;
- (4) тухайн гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний цар хүрээ;
- (5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол;
- (6) [хүчингүй]
- (7) техник үйлчилгээний хөтөлбөр;
- (8) тухайн гэрчилгээ эзэмшигчийн техник үйлчилгээг гүйцэтгэдэг, эсхүл сургалтыг зохион байгуулдаг гэрээт байгууллага;
- (9) тухайн нислэгийн болон ажил үүргийн схем;
- (10) шаардлагатай тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.

(c) [хүчингүй]

(d) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлтийг хийх үед, эсхүл хийсний дараа агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг тогтоож болно.

(e) Тухайн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-гийн дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(f) Хэрэв энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлт нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг шаардсан бол, гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг зохих тэмдэглэл хийлгэхээр нэн даруй Даргад хүргүүлэх үүрэгтэй.

119.167. Техник үйлчилгээний хөтөлбөрийн өөрчлөлт

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, Дарга тухайн хөтөлбөрийн НТЧ-ын хадгалалтын шаардлагыг хангахад шаардлагатай гэж үзсэн аливаа өөрчлөлтийг, Даргын шаардсан даруйд, техник үйлчилгээний хөтөлбөртөө оруулна.

119.169. [Хүчингүй]**119.201. ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаа эрхэлдэг шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт**

(a) Энэ зүйл нь:

- (1) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхээр шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчид хамаарна.

(b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжилтийн огнооноос өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:

- (1) 119.51(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.79, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн, хадгалах шаардлагын оронд ИНД-119.205-д нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлсэн бол;
- (3) 119.81(a)(1A)(i);
- (4) 119.81(a)(3)(ii);
- (5) 119.81(a)(6A).

(c) Гүйцэд бөглөсөн САА маягт, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (i) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш.
- (ii) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2018 оны 12 сарын 31-ний дотор.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;
- (2) 119.79-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх тухайн байгууллагын төлөвлөгөөний дүрслэл.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
- (f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:
- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
- (4) гэрчилгээ сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах аливаа байгууламж, тоног төхөөрөмж, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2019 оны 7 сарын 1-ээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээ сунгуулах хүсэлтэндээ хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.
- (h) Энэ зүйл нь 2019 оны 7 сарын 1-нд хүчингүй болно.

119.203. ИНД-135-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

- (a) Энэ зүйл нь:
- (1) ИНД-135.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-135.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхээр шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчид хамаарна.
- (b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжилтийн огнооноос өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:
- (1) 119.51(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.79, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн, хадгалах шаардлагын оронд ИНД-119.205-д нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлсэн бол;
- (3) 119.81(a)(1A)(i);
- (4) 119.81(a)(3)(ii);
- (5) 119.81(a)(6A).
- (c) Гүйцэд бөглөсөн САА маягт, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш.
- (2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2018 оны 7 сарын 31-ний дотор.
- (d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;
- (2) 119.79-ын дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх тухайн байгууллагын төлөвлөгөөний дүрслэл.
- (e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:
- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
- (f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:
- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
- (4) гэрчилгээ сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах аливаа байгууламж, тоног төхөөрөмж, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2021 оны 2 сарын 1-ээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээ сунгуулах хүсэлтэндээ хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.205. Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт

(a) Тухайн байгууллага энэ Дүрэмд шаардсан журмыг хэрэгжүүлж байгаа болон тохирч байгааг бататгах зорилгоор, 119.201(b)(1)(ii), эсхүл 119.203(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлсэн байх үүрэгтэй.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:

- (1) хэрэг явдлыг ИНД-12-ын дагуу шинжлэн шалгах журмыг багтаасан, **аюулгүй байдлын бодлого** болон аюулгүй байдлын бодлогын журам;
- (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл үндсэн шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн мэдээлэл болон ажилтан, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтэд хийх мониторинг багтаасан, **чанарын үзүүлэлтийг** бататгах журам;
- (3) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудлыг засаж залруулсныг бататгах **залруулах арга хэмжээний** журам;
- (4) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудлын бодит шалтгааныг арилгасныг бататгах **урьдчилан сэргийлэх арга хэмжээний** журам;
- (5) Ерөнхий зааварт тусгасан журмын нийцэл, аюулгүй байдлын бодлогод тусгасан зорилтын хэрэгжилтийг хүсэлт гаргагчийн байгууллагад хянах **дотоод аудитын хөтөлбөр**;
- (6) энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгаа дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны үр дүнтэй байдал, цаашдын оновчтой байдлыг бататгах, статистикийн дүн шинжилгээний ашиглалтыг багтаасан, **удирдлага хяналтын** журам.

(c) Аюулгүй байдлын бодлогын журам нь, тухайн аюулгүй байдлын бодлого байгууллагын бүх түвшинд ойлгомжтой, хэрэгждэг ба дагаж мөрддөг болохыг бататгах ёстой.

(d) Залруулах арга хэмжээний журамд:

- (1) оршин байгаа хүндрэлтэй асуудлыг хэрхэн засаж залруулах;
- (2) засаж залруулах арга хэмжээний үр дүнг хэрхэн эргэн нягтлах талаар тусгасан байх ёстой.

(e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд:

- (1) бодит хүндрэлтэй асуудлыг хэрхэн засаж залруулах;
- (2) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг хэрхэн эргэн нягтлах;
- (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн, энэ Дүрмээр шаардсан аливаа журамд хэрхэн нэмэлт өөрчлөлт оруулах талаар тусгасан байх ёстой.

(f) Чанарын дотоод аудитын хөтөлбөрт дараах ажиллагааг тусгасан байх ёстой:

- (1) аудит хийх тухайн үйл ажиллагааны шинж чанарыг тооцон, аудит хийх байршил, давтамжийг тогтоох;
 - (2) аудит хийгдэж байгаа тухайн үйл ажиллагааг шууд хариуцдаг этгээдээс хамааралгүй бие даасан, сургалтад хамрагдсан аудитын ажилтан тухайн аудитыг хийдэг болохыг бататгах;
 - (3) аудитын үр дүнг, аудит хийсэн тухайн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан болон дотоод аудит хариуцсан менежерт тайлагнадаг болохыг бататгах;
 - (4) сүүлчийн аудитаас хойш, аудит хийсэн тухайн үйл ажиллагаа хариуцсан этгээдийн авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнтэй байдлыг дүгнэх;
 - (5) хэрэв тухайн аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол, аудит хийсэн тухайн үйл ажиллагаа хариуцсан этгээдээс урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;
 - (6) аливаа урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор эргэн нягтлах аудит хийдэг болохыг бататгах.
- (g) Удирдлагын үнэлгээний журамд:
- (1) тухайн тогтолцооны цаашдын үр дүнтэй байдлын хэрэгцээ шаардлагыг тооцон, тухайн чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын үнэлгээ хийх давтамжийг тогтоох;
 - (2) чанар баталгаажуулалтын тогтолцооны үнэлгээ хариуцсан менежерийг тогтоох;
 - (3) тухайн үнэлгээний үр дүнг бүртгэж, үнэлсэн болохыг бататгах.
- (h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй.
- (i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1 хүртэл хүчинтэй.

119.207. Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

(a) Энэ зүйл нь:

- (1) ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчид хамаарна.

(b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжилтийн огнооноос өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:

- (1) 119.101(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.124, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн, хадгалах шаардлагын оронд ИНД-119.209-д нийцсэн байгууллагын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн бол;
- (3) 119.125(a)(1A)(i);
- (4) 119.125(a)(3)(ii);
- (5) 119.125(a)(6A).

(c) Гүйцэд бөглөсөн САА маягт, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2018 оны 1 сарын 1-ээс хойш.
- (2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2018 оны 7 сарын 31-ний дотор.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон огноог багтаасан байх;
- (2) 119.124-ийн дагуу шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх тухайн байгууллагын төлөвлөгөөний дүрслэл.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу огноог тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;

- (4) гэрчилгээ сунгах хугацаа;
 - (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах аливаа байгууламж, тоног төхөөрөмж, эсхүл хуваарийн нөлөө;
 - (6) хэрэгжүүлэлтийн огноо нь 2021 оны 2 сарын 1-ээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээ сунгуулах хүсэлтэндээ хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.209. Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагчийн, байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт

- (a) Тухайн байгууллага энэ Дүрэмд шаардсан журмыг хэрэгжүүлж байгаа ба тохирч байгааг бататгах зорилгоор, 119.207(b)(1)(ii)-т шаардсан байгууллагын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн байх үүрэгтэй.
- (b) Тухайн байгууллагын удирдлагын тогтолцооны журам нь, байгууллагын холбогдох журмыг тухайн байгууллагын бүх түвшинд ойлгож хэрэгжүүлдэг ба дагаж мөрддөг болохыг бататгах зорилгоор тухайн үйл ажиллагааны хэмжээ, төвөгшлийг тооцон дэлгэрэнгүй байх ёстой.
- (c) Энэ зүйлийн (e)-д зааснаас бусад тохиолдолд, байгууллагын удирдлагын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:
- (1) хэрэг явдлыг ИНД-12-ын дагуу шинжлэн шалгах журмыг багтаасан, аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;
 - (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл үндсэн шалтгааныг тогтоох зорилгоор ажилтнууд, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтэд мониторинг хийдгийг бататгах журам;
 - (3) тухайн тогтолцоонд илэрсэн хүндрэлтэй асуудал, эсхүл бодит хүндрэлтэй асуудлыг:
 - (i) залруулсан болохыг;
 - (ii) аливаа залруулга нь үр дүнтэй болсныг бататгах зорилгоор шалгадаг болохыг бататгах журам.
 - (4) тухайн байгууллагын хөтөлбөр, журам нь түүний аюулгүй байдлын бодлогод тусгагдсан зорилтод хүрснийг шалгах журам;
 - (5) тухайн байгууллагын удирдлага нь энэ Дүрмийн шаардлагыг үргэлжлүүлэн үр дүнтэй хангаж байгааг бататгах, дараах шаардлагыг багтаасан журам:
 - (i) үнэлгээ хийх байнгын төлөвлөгөөтэй байх;
 - (ii) тухайн үнэлгээний үр дүн, илэрсэн хүндрэлтэй асуудлыг залруулсан арга хэмжээг багтаасан, ажилтнуудад байнга мэдээлдэг байх.
- (d) Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх аливаа асуудлаар гүйцэтгэх захиралтай шууд харьцах үүрэгтэй.

(е) Энэ зүйлийн (с) нь дараах төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, эсхүл гүйцэтгэхээр зорьж байгаа байгууллагад хамаарахгүй:

(1) Үйл ажиллагааны тодорхойлолтод нь гурав, эсхүл түүнээс цөөн агаарын хөлөг багтсан;

(2) нийт хоёр, эсхүл түүнээс цөөн баазтай.

(f) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

Хавсралт А - Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил, дадлага туршлага

Энэ Хавсралт нь 119.51(b)(1)(i), (ii), (iii) болон (iv)-ийн дагуу хариуцлага хүлээх удирдах ажилтны мэргэшил, дадлага туршлагын шаардлагыг тогтооно.

А.1. Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа		
Шаардагдах бичиг	баримт	Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй
Агаарын хөлгийн даргын дадлага туршлага		3 жил, ИНД-121-ийн үйл ажиллагааны хүрээнд агаарын хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх
Удирдан байгуулах туршлага	зохион дадлага	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүргийг гүйцэтгэсэн байх

	ИНД-125-ын үйл ажиллагаа		ИНД-135-ын үйл ажиллагаа
	Олон нисгэгчтэй	Ганц нисгэгчтэй	
Шаардлагатай баримт бичиг	Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтаж байгаа бол,	Хавсралт В-г харах
Хөлгийн даргын дадлага туршлага	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын дагуух үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх; эсхүл ↓	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын дагуух үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх; эсхүл ↓	Хавсралт В-г харах
Удирдах ажлын дадлага туршлага	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн байх	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн байх	Хавсралт В-г харах

А.2. Багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа	
Шаардлагатай баримт бичиг	Холбогдох зэрэглэл бүхий агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэх эрхтэй
Дадлага туршлага	ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаанд 3 жил хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх ба нислэгийн шалгалт, сургалт хийсэн 2 жилийн дадлага туршлагатай байх.

	ИНД-125-ын үйл ажиллагаа		ИНД-135-ын үйл ажиллагаа
	Олон нисгэгчтэй	Ганц нисгэгчтэй	
Шаардлагатай баримт бичиг	Холбогдох зэрэглэл бүхий агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтаж байгаа бол,	Хавсралт В-г харах
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэх эрхтэй	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэх эрхтэй	Хавсралт В-г харах
Дадлага туршлага	ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаанд 3 жил хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх ба нислэгийн шалгалт, сургалт хийсэн 2 жилийн дадлага туршлагатай байх	ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаанд 3 жил хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх ба нислэгийн шалгалт, сургалт хийсэн 2 жилийн дадлага туршлагатай байх	Хавсралт В-г харах

Хэрэв тухайн этгээд нь Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа агаарын тээврийн үйл ажиллагааны дүйцэх дадлага туршлагатай, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх маягийн үйл ажиллагааны дадлага туршлагатай бол, тухайн этгээдийг ИНД-121, ИНД-125, эсхүл ИНД-135-ын үйл ажиллагааны дадлага туршлагын шаардлагыг хангасан гэж үнэлгээ хийж болно.

А.3. Техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан

А.3.1. ИНД-121-ийн үйл ажиллагаа

(а) ИНД-121-ийн дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-121-ийн техник үйлчилгээний холбоотой шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох аливаа шалгалт, эсхүл тест өгсөн байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан удирдах ажилтан нь:

- (1) дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
 - (i) зохих зэрэглэл бүхий, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх үнэмлэх эзэмшдэг, эсхүл эзэмшиж байсан байх;
 - (ii) тухайн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний 5-аас доошгүй жилийн дадлага туршлагатай байх;
 - (iii) хяналтын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг энэ хэсгийн (1)(ii)-т шаардсан 5 жилийн дадлага туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно; эсхүл
- (2) дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
 - (i) нисэхийн, механикийн, эсхүл цахилгааны чиглэлээр инженерийн, эсхүл түүнтэй дүйцэх мэргэжлээр төгссөн байх;
 - (ii) агаарын хөлгийн техник үйлчилгээний 5-аас доошгүй жилийн дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг техник үйлчилгээний хяналт, төлөвлөлт, инженерингийн боловсруулалт, эсхүл засвар үйлчилгээний ажлын орчинд олж авсан байж болно;
 - (iii) агаарын хөлгийн техник үйлчилгээний ажлыг гардан гүйцэтгэсэн 6-аас доошгүй сарын практик дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг энэ хэсгийн (2)(ii)-ын дагуу шаардсан 5 жилийн дадлага туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно;
 - (iv) хяналтын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг энэ хэсгийн (2)(ii)-т шаардсан 5 жилийн дадлага туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно;

(с) Энэ зүйлийн (b)(1)(ii), (b)(2)(ii)-ын дадлага туршлагын шаардлагыг, ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэсэн, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгааны сургалтын курсэд хамрагдсанаар хангаж болно.

А.3.2. ИНД-125-ын үйл ажиллагаа

(а) ИНД-125-ын дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-125-ын техник үйлчилгээний холбоотой шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох аливаа шалгалт, эсхүл тест өгсөн байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан удирдах ажилтан нь:

- (1) Хавсралт А.3.1-ийн шаардлагыг хангасан байх; эсхүл
- (2) дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
 - (i) хууль болон ИНД-66-гийн дагуу олгосон зохих зэрэглэл бүхий, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх үнэмлэх эзэмшдэг, эсхүл эзэмшиж байсан байх;
 - (ii) тухайн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний 3-аас доошгүй жилийн дадлага туршлагатай байх;
 - (iii) агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхээр ажилласан 1-ээс доошгүй жилийн дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг хэсгийн (ii)-т шаардсан 3 жилийн дадлага туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно; эсхүл,
- (3) тухайн байгууллага үйл ажилгаандаа ашигладаг агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний хяналт, удирдлага болон НТЧ-ын хадгалалтыг хариуцан ажилласан 5-аас доошгүй жилийн дадлага туршлагыг багтаасан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц дадлага туршлагатай байх үүрэгтэй.

(с) Энэ зүйлийн (b)(2)(ii)-ын дадлага туршлагын шаардлагыг, ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэсэн, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгааны сургалтын курсэд хамрагдсанаар орлох өөр хэлбэрээр хангаж болно.

А.4. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны холбогдох ур чадвараа харуулсан байх. Холбогдох ИНД, аюулгүй байдлын удирдлагын шаардлагын талаар ажилласан мэдлэгтэй байх.
Дадлага туршлага	Аюулгүй байдлын тогтолцооны удирдлага болон тухайн байгууллагын ажиллагаатай холбоотой суурь мэргэжил, дадлага туршлагатай байх.

А.5 Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан

	ИНД-121-ийн үйл ажиллагаа	ИНД-125/135-ын үйл ажиллагаа
Шаардлага тай баримт бичиг	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх; эсхүл ↓ 5 жил, нисэхийн салбарт чанар баталгаажуулалтын удирдлагын чиглэлээр ажилласан дадлага туршлагатай байх;	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх; эсхүл ↓ 5 жил, нисэхийн салбарт чанар баталгаажуулалтын удирдлагын чиглэлээр ажилласан дадлага туршлагатай байх;
Дадлага туршлага	5 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн дадлага туршлагатай байх;	5 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн дадлага туршлагатай байх;

Хэрэв тухайн этгээд нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц чанар баталгаажуулалтын дүйцэх дадлага туршлагатай бол, тухайн удирдах ажилтны албан тушаалын мэргэшлийн шаардлагыг хангасан гэж үнэлгээ хийж болно.

Хавсралт В - Удирдах ажилтны мэргэшил, дадлага туршлага - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч

Энэ Хавсралт нь 119.101(b)(1)(i), (ii), (iii) болон (iv)-ийн дагуу хариуцлага хүлээх удирдах ажилтнуудын мэргэшил, дадлага туршлагын шаардлагыг тогтооно.

В.1. Төлбөрт нислэгийн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй, эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол;	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол;
Хөлгийн даргын дадлага туршлага	3 жил, ИНД-135-ын дагуух үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн байх ба, 750 нислэгийн цаг, тухайн ашиглах ижил категорийн агаарын хөлгөөр төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц ижил, эсхүл төстэй төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх ба; 75 цаг, бодит, эсхүл дуураймал нислэгийн туршлагатай байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол; эсхүл ↓	500 нислэгийн цаг, тухайн ашиглах ижил категорийн агаарын хөлгөөр төлбөрт нислэгийн үйл ажиллагаанд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц ижил, эсхүл төстэй төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх ба; 75 цаг, бодит, эсхүл дуураймал нислэгийн туршлагатай байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол; эсхүл ↓
Удирдах ажлын дадлага туршлага	3 жил, Даргын хүлээн зөвшөөрөхүйц төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн дадлага туршлагыг багтаасан, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх	2 жил, Даргын хүлээн зөвшөөрөхүйц төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн дадлага туршлагыг багтаасан, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх

Дээр заагдсан удирдах ажилтнуудын дадлага туршлагын шаардлагад үнэлгээ хийхдээ Дарга дараах дадлага туршлагыг нь тооцож болно:

- (a) хөлгийн дарга байх шаардлагатай мэргэшсэн удирдах ажилтны хувьд, Дарга цэргийн үйлчилгээний үйл ажиллагааг багтаасан ижил төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагааны, эсхүл төстэй үйл ажиллагааны орчин, тоног төхөөрөмжийн төрөл болон агаарын хөлгийн конфигурацитай, төстэй төрлийн төлбөрт нислэгийн үйл ажиллагааны туршлагыг тооцож болно;
- (b) удирдан зохион байгуулах дадлага туршлагатай байх шаардлагатай мэргэшсэн удирдах ажилтны хувьд, Дарга төлбөрт нислэгийн үйл ажиллагааны, эсхүл цэргийн төстэй тээврийн үйл ажиллагаанд ажилласан нислэгийн үйл ажиллагааны хяналтын дадлага туршлага, эсхүл төстэй дадлага туршлагыг тооцож болно.

В.2. Багийн гишүүдийн сургалт, ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй болон/эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй болон/эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол;	Хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байх, хэрэв үйл ажиллагаанд ХНД багтдаг бол;
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэх эрхтэй	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэх эрхтэй
Дадлага туршлага	3 жил, 135-ын үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай байх ба, 2 жил, нислэгийн шалгалт, сургалт хийсэн дадлага туршлагатай байх	-

В.3. Техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан

(a) ИНД-135-ын дагуу төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага, төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-135-ын техник үйлчилгээний холбоотой шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;

- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлагыг хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох аливаа шалгалт, эсхүл тест өгсөн байх.
- (b) Энэ зүйлийн (a)-д заасан удирдах ажилтан нь:
- (1) Хавсралт А.3.1-ийн шаардлагыг хангасан байх; эсхүл
- (2) Хавсралт А.3.2-ийн шаардлагыг хангасан байх; эсхүл
- (3) нийт 3, эсхүл түүнээс цөөн агаарын хөлөг Үйл ажиллагааны тодорхойлолтод заагдсан ба 2, эсхүл түүнээс цөөн баазаас төлбөрт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр зорьж байгаа, эсхүл гүйцэтгэж байгаа байгууллагын хувьд, тухайн агаарын хөлөг нь нислэгт тэнцэх нөхцөлд хадгалагдаж байгаа ба түүний техник үйлчилгээний хөтөлбөрт шаардсан аливаа техник үйлчилгээг зохих ёсоор хийдэг болохыг бататгах чадвартай байх зорилгоор хангалттай техник үйлчилгээний мэдлэгтэй байх.
- (c) Энэ зүйлийн ((b)(3)-ын дадлага туршлагын шаардлагыг, ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэсэн, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгааны сургалтын курсэд хамрагдсанаар хангаж болно.

В.4. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвараа харуулсан байх. Холбогдох ИНД, аюулгүй байдлын удирдлагын шаардлагын талаар ажилласан мэдлэгтэй байх.
Дадлага туршлага	Аюулгүй байдлын тогтолцооны удирдлага болон тухайн байгууллагын ажиллагаатай холбоотой суурь мэргэжил, дадлага туршлагатай байх.

В.5. Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй болон/эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй болон/эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх эсхүл ↓	Чанар баталгаажуулалт, эсхүл удирдлагын тогтолцооны ерөнхий мэдлэг, ойлголттой байх
	Чанар баталгаажуулалт, эсхүл	

	удирдлагын тогтолцооны ерөнхий мэдлэг, ойлголттой байх эсхүл ↓	
	2 жил, нисэхийн салбарт удирдлагын тогтолцооны чиглэлээр ажилласан дадлага туршлагатай байх;	
Дадлага туршлага	3 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн дадлага туршлагатай байх;	

Хэрэв тухайн этгээд нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц чанар баталгаажуулалтын дүйцэх дадлага туршлагатай бол, тухайн этгээдийг удирдах ажилтны албан тушаалын мэргэшлийн шаардлагыг хангасан гэж үнэлгээ хийж болно.

--oOo--